

## Маргааны товч

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын гаалийн улсын байцаагч Ш.Батболдын 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн “Зөрчилд шийтгэл оногдуулах тухай” 0012519 дүгээр шийтгэлийн хуудсаар “... тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээд биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортолсон зөрчил гаргасан” гэж “Хюманстэйшн интернэшнл” ХХК-ийг 1,000,000 төгрөгийн торгууль, зөрчилд холбогдох 80 хайрцаг бүтээгдэхүүнийг хураан авч шийдвэрлэжээ.

“Хюманстэйшн интернэшнл” ХХК-иас уг шийдвэрийг эс зөвшөөрч “... 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс хойш иргэн, аж ахуй нэгжүүд нь тусгай зөвшөөрөл авалгүйгээр биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортлох үйл ажиллагааг чөлөөтэй эрхэлж байгаа ба уг үйл ажиллагааг зөрчилд тооцохоо больсон байхад Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын тухай хуулийн 15.9.3-д “биологийн идэвхт бүтээгдэхүүн”-ийг хамруулсан нь хуулийн “хийдэл” болохыг харуулж байна. “Хюманстэйшн интернэшнл” ХХК нь тусгай зөвшөөрөлгүйгээр биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортолсон үйлдэл нь одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу “зөрчил”-д тооцогдохоо больсон ба Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 4-д зааснаар хууль буцаан хэрэглэх үндэслэлтэй” гэж,

Хариуцагчаас ““Хюманстэйшн интернэшнл” ХХК нь 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдөр хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, дархлаа дэмжих цай гэх 42 нэр төрлийн бараанд гаалийн бүрдүүлэлт хийж импортлогдсон. Уг бараанууд нь Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Биологийн идэвхт бүтээгдэхүүний салбар зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 10 дугаар хуралдаанаар “биологийн идэвхт бүтээгдэхүүн” гэж тодорхойлсон бүтээгдэхүүнүүд бөгөөд тусгай зөвшөөрөл аваагүй атлаа биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортолсон нь Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил мөн, уг зөрчилд шийтгэл оногдуулсан нь үндэслэлтэй” гэж тус тус маргажээ.